

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БНА-2026/001/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Баянхонгор хот</p> <p>2026 оны 03 дугаар сарын 15</p> <p><b>2026</b></p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат</p> <p>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: М.Алтантуяа</p> <p>Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Энхзул</p> <p>Утас: 99333147 Цахим хаяг: enkhzulg@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	3
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	4
5.1 Төлбөрийн акт .....	4
5.2 Албан шаардлага .....	5
5.3 Зөвлөмж .....	5
6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	6

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

*/төгрөгөөр/*

Д/д	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	21,483,639.00	24,509,757.64
1.1.2	Дансны авлага	5,041,983.15	967,264.98
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>26,525,622.15</b>	<b>25,477,022.62</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	8,056,000.00	18,441,430.20
1.2.2	Биет бус хөрөнгө	-	732,449.32
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>8,056,000.00</b>	<b>19,173,879.52</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>34,581,622.15</b>	<b>44,650,902.14</b>
2.1.1.3	Татварын өр	2,967,680.00	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,967,680.00	-
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>2,967,680.00</b>	<b>-</b>
2.3.1	Төрийн өмч	31,613,942.15	31,613,942.15
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-	13,036,959.99
2.3.11	Эздийн өмчийн дүн	31,613,942.15	44,650,902.14
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>34,581,622.15</b>	<b>44,650,902.14</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

*/төгрөгөөр/*

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант үеийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	44,154,633.00	66,281,226.47
03	Нийт ашиг (алдагдал)	44,154,633.00	66,281,226.47
10	Ерөнхий ба удирдлагын зардал	35,105,414.00	53,244,266.48
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	9,049,219.00	13,036,959.99
20	Татварын дараах ашиг (алдагдал)	9,049,219.00	13,036,959.99
22	Тайлант үеийн ашиг (алдагдал)	9,049,219.00	13,036,959.99
24	Орлогын нийт дүн	9,049,219.00	13,036,959.99

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

*/төгрөгөөр/*

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант үеийн дүн
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>60,555,433.00</b>	<b>70,394,544.64</b>
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	60,555,433.00	70,394,544.64
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>45,330,798.00</b>	<b>56,208,526.00</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	20,367,905.00	23,111,589.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,346,150.00	4,108,340.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	8,538,800.00	11,136,600.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	910,000.00	-

**Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан**

1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,990,000.00	4,801,320.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,239,175.00	4,993,801.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	7,938,768.00	8,056,876.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	15,224,635.00	14,186,018.64
2.2	Мөнгөн зарлагын дүн	-	11,159,900.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	11,159,900.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(11,159,900.00)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	15,224,635.00	3,026,118.64
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	6,259,004.00	21,483,639.00
7	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	21,483,639.00	24,509,757.64

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

*/төгрөгөөр/*

Д/д	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	31,613,942.15	-	-	31,613,942.15
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	-	-	13,036,959.99	13,036,959.99
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
17	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	31,613,942.15	-	13,036,959.99	44,650,902.14

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 14,334.1 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>1</sup> илэрсэнд 1 төлбөрийн акт, цаашид давтан гаргахгүй байх зөрчлийг арилгах 1 албан шаардлага, алдааг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

**5.1 Төлбөрийн акт**

5.1.1 Тайлант хугацаанд байгууллагын даргын хувийн гар утасны 300.0 мянган төгрөгийн төлбөрийг байгууллагын зардлаас төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх "Үндсэн үйл ажиллагаа нь шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны гар утасны зардлаас бусад гар утасны зардал" гэсэн заалтыг дагаж мөрдөөгүй байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Шийдвэрлэсэн нь:** Зориулалт бусаар зарцуулсан 300.0 мянган төгрөгийг байгууллагын даргаар 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

## 5.2 Албан шаардлага

5.2.1 Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 13,275.6 мянган төгрөгийн 2 гүйлгээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5 дахь "Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, тэдгээрийн задаргаа", 6.4.5 дахь "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.5-д заасан мэдээллийг бүрэн байршуулж зөрчлийг арилган, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

## 5.3 Зөвлөмж

5.3.1 Тус байгууллага нь төсөв зарцуулахдаа Эрчим хүчний зохицуулах хорооны хянасан зардлын төсвөөс хэтрүүлэн баталж, зарцуулсан байна. Тухайлбал, байгууллагын эзэмшилд тээврийн хэрэгсэл бүртгэлгүй байхад 258.5 мянган төгрөгийн масло, маслын шүүр, 500.0 мянган төгрөгийн 2ш дугуй, нийт 758.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 33 дугаар тогтоолын хавсралт дахь 04 дүгээр зүйлийн 4.1.3 дахь "Эрчим хүчний зохицуулах хорооны хянасан Зохицуулах зөвлөлийн зардлын төсвийг зохицуулах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн зохицуулалтын үйлчилгээний хөлсний хамт батлуулах, захиран зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Цаашид зардлын төсвийг батлахдаа Эрчим хүчний зохицуулах хорооноос хянасан зардлын төсвийг баталж, зарцуулж байх зөвлөмж өгөв.

5.3.2 Тус байгууллагын дарга нь "ФЮМ" ХХК-ийн "Тариф шинэчлэн батлах тухай" тогтоолыг гаргахдаа нэг дугаар дээр тариф мөрдөж эхлэх огноог хоёр өөр огнооноос эхэлж мөрдөхөөр тогтоол гаргасан байна.

Энэ нь Захиргааны Ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2.Захиргааны хэм хэмжээний акт нь энэ хуулийн 67.1-д заасны дагуу нийтэлснээр хүчин төгөлдөр болно. Захиргааны хэм хэмжээний актад дагаж мөрдөх хугацааг өөрөөр зааж болно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Цаашид "Тариф шинэчлэн батлах тухай" тогтоолыг гаргахдаа Захиргааны Ерөнхий хуулийн заалт болон холбогдох үндэслэлийн дагуу гаргаж байх зөвлөмж өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс		Төлбөрийн акт		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацаанд байгууллагын даргын хувийн гар утасны 300.0 мянган төгрөгийн төлбөрийг байгууллагын зардлаас төлсөн байна.	1	300.0	1	300.0				
Тус байгууллага нь төсөв зарцуулахдаа Эрчим хүчний зохицуулах хорооны хянасан зардлын төсвөөс хэтрүүлэн баталж, зарцуулсан байна. Тухайлбал, байгууллагын эзэмшилд тээврийн хэрэгсэл бүртгэлгүй байхад 258.5 мянган төгрөгийн масло, маслын шүүр, 500.0 мянган төгрөгийн 2ш дугуй, нийт 758.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	-					1	-
Тус байгууллагын дарга нь "ФЮМ" ХХК-ийн Тариф шинэчлэн батлах тухай тогтоолыг гаргахдаа нэг дугаар дээр тариф мөрдөж эхлэх огноог хоёр өөр огнооноос эхэлж мөрдөхөөр тогтоол гаргасан байна.	1	-					1	-
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>300.0</b>	<b>1</b>	<b>300.0</b>			<b>2</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс		Төлбөрийн акт		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой</b>								
Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 13,275.6 мянган төгрөгийн 2 гүйлгээг байршуулаагүй байна.	1	13,275.6			1	13,275.6		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>13,275.6</b>			<b>1</b>	<b>13,275.6</b>		

-----oOo-----



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 77/А0571284/БНА-2026/001/ Номгон  
НА-СТА-ТӨВГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын даргын хувийн гар утасны 300,000 (Гурван зуун мянган) төгрөгийн төлбөрийг байгууллагын зардлаас төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх "Үндсэн үйл ажиллагаа нь шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны гар утасны зардлаас бусад гар утасны зардал" гэсэн заалтыг дагаж мөрдөөгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зориулалт бусаар зарцуулсан 300,000 (Гурван зуун мянган) төгрөгийг байгууллагын даргаар нөхөн төлүүлж Төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төвлөрүүлж, зөрчлийг арилгасан талаарх нотлох баримтыг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.


2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн дарга А.Түвшинбилэг, нягтлан бодогч Б.Даваасүрэн нарт даалгав<sup>1,2</sup>.

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН<sup>3</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: *Б.Мөнхбат* Б.МӨНХБАТ

АУДИТОР:

*Г.Энхзул* Г.ЭНХЗУЛ



<sup>1</sup>Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

<sup>2</sup>Монгол улсын ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>3</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 195/АД571284/БНА-2026/001/Номгон  
НА-СТА-ТӨВГ.

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 13,275,600 (Арван гурван сая хоёр зуун далан таван мянга зургаан зуун) төгрөгийн 2 гүйлгээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5 дахь “Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, тэдгээрийн задаргаа”, 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

6426090915

/documents/2026 он/1. бичиг  
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст холбогдох мэдээллүүдийг нөхөн байршуулж, нотлох баримтыг 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.


2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн дарга А.Түвшинбилэг, нягтлан бодогч Б.Даваасүрэн нарт нарт даалгав<sup>1,2</sup>.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: *[Signature]* Б.МӨНХБАТ

АУДИТОР: *[Signature]*

Г.ЭНХЗУЛ



<sup>1</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>2</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>3</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно